



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Тавантолгой

**“Тавантолгой” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.13 дэх заалт, Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр гаргасан санал дүгнэлтийг 2022 оны үйл ажиллагааны бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Тавантолгой

**“Тавантолгой” ХК-ийн 2021 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Түвшинбаяр/, Гүйцэтгэх захирал Ж.Доржсүрэнд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 03

Тавантолгой

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.13 дэх заалт, Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2020 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашиг болгон хуваарилах талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 43 тоот тогтоолыг дэмжиж зөвшөөрсөн гэж дүгнэсүгэй.

2. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 04

Тавантолгой

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.7 дэх заалт, Тооллогын комиссын 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

- 1.1. Г.Цог-Өрнөх / ердийн гишүүн /
- 1.2. Ц.Даваацэрэн / ердийн гишүүн /
- 1.3. Ш.Баянбат / ердийн гишүүн /
- 1.4. Д.Дагвадорж / ердийн гишүүн /
- 1.5. Г.Ганчимэг / ердийн гишүүн /
- 1.6. С.Мөнхжаргал / ердийн гишүүн /
- 1.7. Б.Түвшинбаяр / хараат бус гишүүн /
- 1.8. Д.Нацагдорж / хараат бус гишүүн
- 1.9. Т.Тэгшээ / хараат бус гишүүн /

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс эхлэн ажиллуулахаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР